



ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



*ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНД ТАВИХ
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.*

Даланзадгад хот
2016 он

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

Агуулга

Тайланг бэлтгэсэн: Байгууллагын дарга, Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр Аудитын менежер Д.Алдармөнх Ахлах аудитор Т.Хонгорзул Аудитор Г.Цэрэнлхам Д.Сүрэнжаргал Шинжээч Ш. Отгонбаяр Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт Бүлэг 1 Хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Бүлэг 2 Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг төлөвлөөгүй, орлогыг төрөл тус бүрээр бүрдүүлээгүй байна. Бүлэг 3 Тусгай сангуудын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Бүлэг 4 Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Дүгнэлт Зөвлөмж Албан шаардлага Хавсралтууд Судалгаа 1 Судалгаа 2
--	--



Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
АИТХТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт

АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах сан, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангуудын үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Хууль эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад аймаг, сумын ЗДТГазар, Политехник коллеж болон холбогдох бусад байгууллагууд хамрагдав.

Засгийн газрын тусгай сангийн хуулиар тодорхойлсон “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”, “Сургалтын төрийн сан” орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаггүй болно.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийх, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, түүвэрчлэн шалгаж үр ашигт байдлыг үнэлэхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

Аудитыг Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр хянан удирдаж, аудитын менежер Д.Алдармөнх аудитын стандартыг хангуулж, аудитыг ахлах аудитор Т.Хонгорзул, аудитор Д.Сүрэнжаргал, Г.Цэрэнлхам, шинжээч Ш.Отгонбаяр нар хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Хууль эрх зүйн зохицуулалтыг
сайжруулах шаардлагатай байна.

1. Байгаль хамгаалах сан

Аймгийн хэмжээнд байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” батлах тухай АИТХТ-ын 2010 оны 12 дугаар тогтоолоор зохицуулж байна.

Мөрдөж байгаа журмын заалтуудыг шинэчлээгүй байгаа нь бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Тухайлбал:

- Журмын 4-д хүчингүй болсон *“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн тухай”* хууль,
- 5.3-д хүчингүй болсон *“Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах. тайлагнах журам”*,
- 5.4-д шинэчлэн найруулагдсан “Ойн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэхь заалтууд байна.

Иймд дээрхи журмыг шинэчлэн батлах тухай зөвлөмжийг АИТХуралд хүргүүлээ.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Сурагчдад мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, сургалтын тэтгэлэг олгох ажиллагааг Мэргэжлийн боловсролын тухай хууль, “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам” батлах тухай Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоол, “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлах тухай Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжүүлэн зохион байгуулсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.9-д хүчингүй болсон төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн заалт байгааг шинэчлэх шаардлагатай байна.

Бүлэг 2

Байгаль хамгаалах сангийн
хөрөнгийг төлөвлөөгүй,
орлогыг төрөл тус бүрээр
бүрдүүлээгүй байна.

1. Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сангийн орлогыг 2015 онд “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” батлах тухай АИТХТ-ын 2010 оны 12 дугаар тогтоолын 6.1 “Аймгийн ЗДТГ-ын байгаль орчны бодлого хариуцсан хэлтэс тухайн оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирэх оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос аймгийн байгаль хамгаалах санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн төлөвлөгөөг гаргаж, санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ” дэх заалтын дагуу төлөвлөж ажиллаагүй байна.

2015 онд 140,4 сая төгрөгийн орлого төвлөрснөөс журамд заасан хандив тусламжийн орлого 9,4 сая төгрөг, журамд тусгагдаагүй Байгалийн ургамалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан нөхөн төлбөр, хураамжийн орлого 57,7 сая төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн данснаас шилжүүлсэн орлого 73,2 сая төгрөг байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн орлого төвлөрүүлэлт 2015 он

Хүснэгт №1

№	Сумын нэр	Төлбөр хураамж	Хандив, тусламж	Нөхөн төлбөрийн барьцаа	/төгрөгөөр/ Мөнгөн дүн
1	Баяндалай		35 000	400 000	435 000
2	Баян-Овоо			29 026 621	29 026 621
3	Булган			1 000 000	1 000 000
4	Гурвантэс		3 096 000	17 180 000	20 276 000
5	Мандал-Овоо		400 000	2 760 658	3 160 658
6	Манлай		156 000	7 196 000	7 352 000
7	Номгон	240 000	600 000	8 550 000	9 390 000
8	Ноён		2 000	2 870 000	2 872 000
9	Ханхонгор			2 199 500	2 199 500
10	Хүрмэн	7002 000			7002 000
11	Цогт-Овоо	121 000	1 000 000	2 080 640	3 201 640
12	Цогтцэций		3 500 000		3 500 000
13	Аймаг	50 406 056	619 516		51 025 572
	ДҮН	57 769 056	9 408 516	73 263 419	140 440 991

2016 онд 61,9 сая төгрөгийн орлого төвлөрснөөс журамд заасан хандив тусламжийн орлого 147,0 мянган төгрөг, журамд тусгагдаагүй Байгалийн ургамалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан нөхөн төлбөр, хураамжийн орлого 34,3 сая төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн данснаас шилжүүлсэн орлого 27,4 сая төгрөг байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

*Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн орлого төвлөрүүлэлт 2016 оны
9 дүгээр сарын байдлаар*

Хүснэгт №2

/төгрөгөөр/

№	Сумын нэр	Төлбөр хураамж	Хандив, тусламж	Нөхөн төлбөрийн барьцаа	Мөнгөн дүн
1	Баяндалай				
2	Баян-Овоо			1 500 000	1 500 000
3	Булган				
4	Гурвантэс			17 355 000	17 355 000
5	Мандал-Овоо			3 496 500	3 496 500
6	Манлай		97 000	3 000 000	3 097 000
7	Номгон				
8	Ноён				
9	Ханхонгор	50 000			50 000
10	Хүрмэн		50 000		50 000
11	Цогт-Овоо				
12	Цогтцэций			2 050 000	2 050 000
13	Аймаг	34 349 500			34 349 500
	ДҮН	34 399 500	147 000	27 401 500	61 948 000

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн бүрдүүлэлтийг журамд тодорхой тусгаж өгөөгүй, хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлаагүйгээс орлогыг төрөл тус бүрээр бүрдүүлээгүй байна.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д заасны дагуу суралцагчдын тэтгэлэгийг 2015 онд 858 оюутанд 540,5 сая төгрөг, 2016 онд 800 оюутанд 504,0 сая төгрөг олгохоор төлөвлөн төсвийн хүрээний мэдэгдлээ Хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн байна.

Сургалцагчдын тэтгэлэгийг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан ирэх оны хичээлийн жилд Хөдөлмөрийн яамнаас баталсан квотыг нэмж төлөвлөлтийг тооцсон байна.

Бүлэг 3

Сангуудын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1. Байгаль хамгаалах сан

2015 онд байгаль хамгаалах сангаас байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах болон орчны доройтлыг бууруулах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд 135,5 сая, байгаль орчныг судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад 14,6 сая, ном товхимол, зурагт хуудас, сурталчилгааны материал хэвлүүлэхэд 4,0 сая, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилд 19,3 сая, зориулалт бусаар 4,7 сая төгрөг, засаг даргын захирамжгүй 3,2 сая төгрөг нийт 181.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Журмын 11 дэх заалтыг зөрчин зориулалт бусаар сангийн хөрөнгөөр бичиг хэргийн материал, тавилга эд хогшил худалдан авсан 4,7 сая төгрөгийн зөрчилд Гурвантэс сумын Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Мөн журмын 8 дах заалтыг зөрчин Засаг даргын захирамжгүй байгаль орчны хяналт, нохой устгалын зардалд 3,2 сая төгрөг зарцуулсан зөрчилд Цогт-Овоо сумын засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

2016 эхний хагас жилд байгаль хамгаалах сангаас байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах болон орчны доройтлыг бууруулах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд 42,7 сая, байгаль орчныг судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад 11,3 сая төгрөг нийт 54,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн хөрөнгийг захиран зарцуулахдаа журмын 9.1, 9.2 дэх заалтын дагуу зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар баталгаажуулан Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга болон сумдын Засаг дарга 1-р гарын үсэг, сан хариуцсан нягтлан бодогчид 2-р гарыг үсэг зурж санхүүжилтийг олгохоор журамлаж өгсөн байна.

Гэвч аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга гарын үсэг зурж зарцуулж байгаа нь журмын дээрхи заалттай нийцэхгүй байна.

Сангийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 4-3/760 дугаар албан тоотын дагуу Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2016 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн №7-1044 дугаар албан тоотоор сумдын байгаль хамгаалах санг хааж, сангийн үлдэгдлийг тухайн сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн дансанд төвлөрүүлэх чиглэл хүргүүлсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

Чиглэлийн дагуу сумдын байгаль хамгаалах сангууд 59,1 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Сумдын байгаль хамгаалах сангийн үлдэгдэл
төвлөрүүлсэн байдал:

Хүснэгт №3

/Төгрөгөөр/

№	Сумдын нэр	Үлдэгдэл төвлөрүүлсэн мөнгөн дүн
1	Баяндалай	1 253
2	Баян-Овоо	29 576 621
3	Булган	752 917
4	Гурвантэс	4 304 350
5	Мандал-Овоо	
6	Манлай	7 443 385
7	Номгон	389 478
8	Ноён	7 851 465
9	Сэврэй	15 965
10	Ханбогд	
11	Ханхонгор	6 920 423
12	Хүрмэн	1 555 617
13	Цогт-Овоо	
14	Цогтцэций	
15	Даланзадгад	354 000
	Нийт дүн	59 165 474

Байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг тус журмын 21-т заасны дагуу жилд 2 удаа хагас бүтэн жилээр тайлагнахаар тусгагдсан заалтыг хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам” батлах тухай Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолын 3.2-д заасан дагуу ирцийн бүртгэлийг сургалтын менежер гаргаж, анги удирдсан багш суралцагчдын хичээлд суусан цагийг гарын үсгээр баталгаалжуулан захиралд хүргүүлсэн байна.

Сургуулийн захирал, нягтлан бодогч дээрхи баримтыг хянан тэтгэлгийн тооцоог гаргаж Хөдөлмөрийн яамны мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн мэргэжилтэнд хүргүүлж ажилласан байна.

2015 онд 687 суралцагчдад 326,1 сая төгрөг, 2016 онд 506 суралцагчдад 172,0 сая төгрөгийн тэтгэлэг олгох тооцоо хүргүүлснийг анги тус бүрээр задлан харуулбал:

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

2015 оны суралцагсадын тэтгэлгийн тооцоо

Хүснэгт №4

/төгрөгөөр/

№	1-р анги	2-р анги	3-р анги	Нийт суралцагсадын тоо	Тэтгэлэг олгох мөнгөн дүн
1	334	189		523	34,376,800
2	334	189		523	9,825,700
3	334	189		523	34,376,800
4	329	189		518	33,939,400
5	230	189		419	27,482,900
6	183			183	5,740,000
9	303	211	160	674	45,239,500
10	317	209	161	687	45,540,000
11	317	209	161	687	45,276,700
12	317	209	161	687	44,368,500
Нийт дүн					326,166,300

Суралцагчдын ирцийн бүртгэлээр 1-9 дүгээр саруудад 190,9 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 192,4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн 110037402 тоот дансанд шилжүүлж 1,4 сая төгрөгийн илүү санхүүжүүлт олгосон байна.

Илүү олгогдсон санхүүжилтийг үйл ажиллагааны зардалд зориулалт бусаар зарцуулсан зөрчилд Политехник коллежийн захиралд албан шаардлага хүргүүлээ.

Тайлант оны 10-12 дугаар сарын сургалтын тэтгэлэг болох 135,1 сая төгрөгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас суралцагчдын дансанд шилжүүлж олгосон байна.

2016 онд ирцийн бүртгэлийн тооцоог гаргаж Хөдөлмөрийн яамны мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн мэргэжилтэнд хүргүүлсэнээр суралцагчдын тэтгэлэг олгогджээ.

2016 оны суралцагсадын тэтгэлгийн тооцоо

Хүснэгт №5

/төгрөгөөр/

№	1-р анги	2-р анги	Нийт суралцагсадын тоо	Тэтгэлэг олгох мөнгөн дүн
1	304	202	506	32,532,100
2	304	202	506	34,790,000
3	304	202	506	30,873,400
4	304	202	506	33,780,000
5	304	202	506	33,060,400
6	214		214	7,490,000
Нийт дүн				172,525,900

2014-2016 оны хичээлийн жилүүдэд ерөнхий боловсролын сургуульд бүртгэлтэй сурагч давхардан суралцаагүй байна.

Бүлэг 4

Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна

1. Байгаль хамгаалах сан

Аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн А/130 дугаар захирамжаар байгаль хамгаалах сангийн зөвлөлийг хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй, хяналтын зөвлөлийг санхүү төрийн сангийн хэлтсийн даргаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсан байна.

Сангийн зөвлөл, хяналтын зөвлөлийн 2015-2016 онуудад үйл ажиллагаагаа явуулаагүй, хяналт хийгээгүй байна.

Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 23 дэх хэсэгт заасны дагуу сумдын ИТХ-ын Тэргүүлэгчид сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу санхүүгийн хяналт, аудитын алба 2015 оны аймгийн байгаль хамгаалах санд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар 7,1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд бүртгээгүй зөрчилд акт үйлдэж хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Политехник коллежийн захирлын 2015 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн б/53 дугаар тушаалаар хяналт шинжилгээ, чанарын баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэнг томилсон байна. 2015-2016 оны хичээлийн жилд хийгдэх ажлын төлөвлөгөөг сургуулийн захирлаар батлуулсан боловч хариуцсан мэргэжилтэн хяналт хийж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу аймаг, сумдын байгаль хамгаалах сангийн мэдээлэлийг тухай бүр, политехник коллеж санхүүжилтийн мэдээллийг сар бүр мэдээллэж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

Байгаль хамгаалах сан:

- “Байгаль хамгаалах санг зохицуулах зарим эрх зүйн орчин бүрдээгүй байна.
- Байгаль хамгаалах сангийн орлогын төлөвлөлт журмын дагуу хийгдээгүй, зарим сумд сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмын дагуу АИТХ-ын Тэргүүлэгчид хяналт тавьж ажиллаагүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг шинэчлэх шаардлагатай байна.
- Суралцагчдад олгох тэтгэлгийг зориулалтын дагуу тооцож олгосон байна.
- Политехник коллежийн хяналт шинжилгээ, чанарын баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн хяналт хийж ажиллаагүй байна.

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Х.Сугирт:

- “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” –ыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлах

АЛБАН ШААРДЛАГА

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд шаардаж байна. Үүнд:

Политехник коллежийн захирал Ж.Нямсанд:

- Хөдөлмөрийн яамнаас суралцагчдын тэтгэлэгт илүү санхүүжүүлсэн 1,4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэх

Гурвантэс сумын Засаг дарга Г.Гангамаад:

- Байгаль хамгаалах сангийн зөвлөлийг байгуулан, зөвлөлийн хурлаар хөрөнгийн зарцуулалтыг хэлэлцэн шийдвэрлэж байх
- Байгаль хамгаалах сангийн журамд заасан зориулалтын дагуу Засаг даргын захирамжийг үндэслэн зарцуулж байх

Цогт-Овоо сумын Засаг дарга С.Төгсбаатарт:

- Байгаль хамгаалах сангийн зөвлөлийг байгуулан, зөвлөлийн хурлаар хөрөнгийн зарцуулалтыг хэлэлцэн шийдвэрлэж байх
- Байгаль хамгаалах сангийн журамд заасан зориулалтын дагуу Засаг даргын захирамжийг үндэслэн зарцуулж байх